

## **ТомЁ ЗУНЫ ЗУСЛАНД МӨРДӨГДӨХ ЖУРАМ**

Та манай зуны зуслангийн дүрэм, журмыг сайтар уншиж танилцан даган мөрдөх шаардлагатай. ТомЁ зуны зуслан хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдыг зан төлөв, ёс зүйн талаарх зааварчилгааг агуулсан тул эцэг эх, сурагчид энэ баримт бичигтэй сайтар танилцана уу. Энэхүү товч танилцуулга нь манай ирц, бүртгэл, ажилтнуудын гар утасны дугаарууд, сурагчийн гарын авлага, ёс зүйн дүрэм болон онцгой тохиолдолд юу хийх зэрэг мэдээллүүдийг агуулсан болно.

### **1. Эхний өдрийн танилцуулга**

Зуны зусланд ирсэн эхний өдрөө танилцуулга сургалтад хамрагдаж дотоод журам, хөтөлбөртэй танилцана. Өрөө бүрт өрөөг ашиглах дотоод журмыг байрлуулна.

### **2. ТомЁ зуны зуслан хөтөлбөрийн байр ашиглах болон хувийн эд зүйлс**

#### **2.1 Зуслангийн байрандаа очих, өрөөнд хуваарилах**

Сурагчид зусланд ирээд урьдчилан хуваарилсан өрөөндөө байрлах ба дур мэдэн өрөө солих, бусад өрөөнөөс ор зөөж оруулах, нэг өрөөнд даац хэтрүүлэн давхар орох зэрэг үйлдэл гаргахыг хориглоно. Хичээл болон бусад үйл ажиллагаанд тус тусын заасан байранд өөрийн хамаарах бүлэгтэйгээ хамт оролцоно.

#### **2.2 Зуны зусланг орхих журам**

Удирдагч багшийн удирдлага дор танилцах аялал хийх, үйл ажиллагааны хуваариас бусад тохиолдолд Зуслангийн бүсээс гарахыг бүх сурагчдад хатуу хориглоно. Хэрэв зуны зусланг түр болон бүр орхих бол эцэг эх, асран хамгаалагч нь гарах зөвшөөрлийн маягтыг бөглөх бөгөөд сурагчдыг эцэг эх, асран хамгаалагчийн хамт Зуны сургуулийн кампусаас гарахыг зөвшөөрнө.

#### **2.3 Өрөө**

Сурагчид байрлаж буй өрөөгөө тохижуулахыг хориглоно. Үүнд зурагт хуудас наах, хананд зурах, эвдрэл гэмтэл зэрэг орно. Мөн өрөөнүүдийг эмх цэгцтэй, хоггүй, цэвэрхэн байлгах хэрэгтэй. Өдөр бүр ороо хурааж цэвэр үзэмжтэй байлгана.

#### **2.4 Өрөөний түлхүүр (чип карт)**

Сурагчид өрөөний түлхүүрийг (чип карт) хаяж гээгдүүлэхгүй хямгадах үүрэгтэй. Хэрэв хаяж гээгдүүлсэн тохиолдолд чип картын төлбөрт 20.000 төгрөг төлөх бөгөөд тэр дор нь удирдагч багшдаа мэдэгдэнэ.

#### **2.5 Эд зүйлсээ хянах**

Зуны сургуульд авчирсан хувийн эд зүйлс, тэр дундаа үнэт зүйлсийг сурагчид хариуцна. ТомЁ зуны зуслангийн баг дээрх эд зүйлсийн хулгай, гэмтлийг хариуцахгүй. Аюулгүй байдлын үүднээс багш, ажилчид зуны зусланд хамрагдахаас өмнө сурагчдын цүнх саванд нэгжлэг хийн хориглосон зүйлс авчирсан тохиолдолд хураан авах ба сургалтын явцад дүрэм, журмыг зөрчсөн эсвэл зөрчсөн байж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа бол

сурагчийн өрөөнд нэвтэрч, сурагчийг байлцуулан эд хөрөнгөнд нь нэгжлэг хийх эрхтэй байна.

## **2.6 Хохирол барагдуулах**

Өрөөний эд зүйлсийг эвдэхгүй ариг гамтай ашиглах үүрэгтэй ба эвдсэн тохиолдолд эцэг, эхэд мэдэгдэх ба гарсан хохирлыг эцэг эх барагдуулах үүрэг хүлээнэ.

## **3. Сургалт болон бусад үйл ажиллагаа болон аялал**

ТомЁ зуны зуслан нь англи хэлний хөтөлбөртэй тул сурагчид англи хэлний хичээлдээ заавал хамрагдах шаардлагатай бөгөөд бусад хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаануудад идэвхтэй оролцох үүрэгтэй. Эдгээр үйл ажиллагаа аялалд сурагчид ажилтнуудын өгсөн бүх зааврыг сонсож, тэднийг дагах нь зүйтэй.

### **3.1 Цаг бүртгэл болон ирц**

Сурагчид бүх үйл ажиллагаа, аялалд цаг тухайд нь оролцож бүртгүүлэх нь чухал юм.

### **3.2 Эрсдэлийг бууруулах**

Бүх аяллын үеэр ажилтнууд сурагчдын зочлох газартай нь урьдчилан танилцаж эрсдэлийн үнэлгээ хийж үйл ажиллагааг явуулна, яаралтай тохиолдолд ашиглах холбоо барих мэдээллээр хангаж ажиллана.

## **4. Өглөө, оройн бүртгэл**

### **4.1 Бүртгэх цаг**

Сурагчид өглөөний 8:30-9:00 цагт өглөөний цайгаа ууж, оройн үйл ажиллагааны эхэн үед болон оройн хаалтын үеэр удирдсан багш оройн тойргоор дахин ирц бүртгэл хийнэ. Энэ хуваарь өдөр өдөрт бага зэрэг өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Эдгээр тохиолдолд сурагчдад урьдчилан мэдээлнэ.

### **4.2 Амрах цаг**

Зуслангийн сурагчид 21:30 минутаас эхлэн өөр өөрсдийн өрөөндөө орж унтах бэлтгэлээ хийж эхлэх ба 22:00 гэхэд гэрэл унтарч амрах цаг эхэлнэ. Амрах цаг эхэлснээс хойш өөр өрөөнд байж болохгүй. Харанхуй болсны дараа байрнаас гарсан эсвэл гарахыг оролдсон аливаа сурагч сахилгын арга хэмжээ авагдах болно.

## **5. Сурагчдын баримтлах зан авир биеэ авч явах зарчим**

### **5.1 Ажилчидтай харьцах**

Зуны зуслангийн суралцагчид үргэлж эелдэг, хүндэтгэлтэй байх ёстой. Багш, ажилчид эсвэл хамт суралцагчдад чиглэсэн бүдүүлэг байдал давтагдсан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Сурагчид яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд ажилтнуудтай гар утасны дугаараараа холбоо барьж болохгүй. Хэрэв та яаралтай бус асуудлаар ажилтантай холбоо барих шаардлагатай бол сурагчид Зуны зуслангийн менежертэй 95153658 дугаараар холбоо барьж, мэдээллийг дамжуулах болно.

## **5.2 Сурагчидтай харьцах**

ТомЁ зуны зуслан нь бүх сурагчиддаа тав тухтай, аюулгүй байдлыг мэдэрч, хамт суралцагчиддаа эерэг, хүндэтгэлтэй хандах орчинг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд Зуны зуслангийн хугацаанд бүх төрлийн дээрэлхэлт, гадуурхалтыг тэвчихгүй байх хатуу бодлоготой гэдгийг сурагчдад сануулж байна. Амаар, бие махбодийн болон интернет эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ('кибер дээрэлхэх') аливаа төрлийн дээрэлхэх үйлдлийг тэвчихгүй. Өөр сурагч эсвэл сурагчид өөрсдийг нь дээрэлхэж байна гэж бодож байгаа сурагчид багш болон менежерт мэдэгдэх ёстой. Ямарваа нэгэн дээрэлхэх төрлийн зан авир гаргасан сурагчид үргэлжлүүлэн зусланд хамруулахгүй сурагчийг зуны сургуулиас чөлөөлөх хэмжээг нэн даруй авна.

## **5.3 Тэгш боломж**

ТомЁ зуны зуслан нь арьсны өнгө, үндэс угсаа, угсаатны гарал үүсэл, хүйс, гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, шашны итгэл үнэмшил, нас зэргээрээ шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхахаас сэргийлэх болон эрх чөлөө, тэгш боломж олгох орчныг бүрдүүлэх зорилготой. Хэрэв сурагч ёс зүйг зөрчиж, өрөөсгөл байдлаар хандвал тухайн сурагчид зан үйлийнх нь талаар албан ёсоор анхааруулах бөгөөд улмаар уг үйлдэл нь давтагдвал зуны зуслангаас гаргах үндэслэл болно.

## **5.4 Хувцаслалт**

Хэдийгээр зуны сургууль нь ямар нэгэн албан ёсны хувцаслалтын дүрэм заагаагүй ч сурагчид зохих ёсоор хувцаслах ёстой. Энэ хүрээнд зохисгүй хувцаслалтад дараах зүйлс орно (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй): хувцсан дээр доромжилсон үг хэллэг хэвлэлттэй байх эсвэл хэт задгай хувцас.

## **5.5 Хувийн ариун цэвэр**

Хувийн ариун цэврийг дээд зэрэгт сахиж соёлч боловсон хандлагаар хандана. Ариун цэврийн өрөөг хэрэглэсний дараа усаа татах, угаалтуурыг цэвэр ашиглах, гараа тогтмол угаах, гутал хувцсаа цэвэр өмсөх бохирдсон бол арчиж цэвэрлэж өмсөх, гэрлээ унтраах, усаа хаах зэргээр байгальд ээлтэй сурагчийн дадалыг өөртөө хэвшүүлэхийг баримтална.

# **6. Хатуу журам**

Зуны сургууль нь бүх сурагчдаас зан үйлийн өндөр стандартыг шаардах бөгөөд манай ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна гэдгийг сурагчид мэдэж байх ёстой.

## **6.1 Согтууруулах ундаа**

ТомЁ зуны зуслан нь бүх төрлийн согтууруулах ундааг хориглоно. Дараах үйлдлийг хийсэн буюу үйлдсэн нь тогтоогдсон сурагчид сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд энэ нь зуны зуслангаас чөлөөлөгдөх үндэслэл болно: архи согтууруулах ундаа хэрэглэсэн / хадгалсан; архи худалдан авах; согтууруулах ундаа тараах/худалдах, түгээх, борлуулахыг оролдох; архи, согтууруулах ундаа агуулсан лонх эсвэл бусад савтай байх, түүний дотор хувийн эд зүйлс болон согтууруулах ундаа хийсэн гэх мэт.

## **6.2 Тамхины хэрэглээ**

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 18 нас хүрээгүй хүнд тамхи болон бусад төрлийн тамхи худалдах нь эрүүгийн гэмт хэрэг, олон нийтэд нээлттэй байр болон бусад газарт тамхи татах нь эрүүгийн гэмт хэрэг юм. Үүний үр дүнд ТомЁ зуны зуслан нь тамхины эсрэг бодлого баримталдаг. Энэхүү бодлогыг зөрчсөн сурагчдад сахилгын шийтгэл ногдуулж, зуны сургуулиас хөөгдөх үндэслэл болно. Багш нар болон сургуулийн менежерүүд ямарваа нэгэн тамхи болон электрон тамхийг сурагчдаас хураан авах эрхтэй ба нэн даруй эцэг эхэд мэдээлнэ.

## **6.3 Зохисгүй зан авир**

Сурагчдын хооронд зохисгүй энхрийлэл үзүүлэхийг хориглож, сурагчид ямар ч тохиолдолд эсрэг хүйсийн хүний өрөө болон байр луу орохыг хатуу хориглоно.

## **6.4 Хууль зөрчих**

ТомЁ зуны зусланд сурагчид хуулийг дагаж мөрдөх ёстой. Хэрэв хууль зөрчвөл сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд сурагчийг зуны зуслангаас чөлөөлөхөд хүргэж болзошгүй.

## **6.5 Хүчирхийлэл**

ТомЁ зуны зусланд хүчирхийлэл, зодоон үйлдэхийг хориглоно. Сурагчийн үйлдсэн аливаа зодоон, хүчирхийлэлд сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд нөхцөл байдлаас хамааран сурагчийг зуны зуслангаас чөлөөлөх болно.

## **7. Гомдол гаргах**

**7.1** Зуны зуслангийн аль ч үед амаар болон бичгээр гомдол гаргаж болно. Сурагчид мөн ажилтнуудын аль ч гишүүнтэй хэдийд ч ярьж болно. Бүх гомдлыг ажилтнуудын баг хянаж, аль болох хурдан шийдвэрлэх болно.

**7.2** ТомЁ зуны зуслан үүнтэй холбоотой гаргасан бүх гомдлыг маш нухацтай авч үзэх болно. Эхлээд удирдагч багш, ноцтой тохиолдолд Захиргааны хэлтэс хянаж шийдвэрлэнэ.

**7.3** Гомдлын хариуг шийдвэрлэсэн даруйд нь мэдэгдэнэ. Хэрэв хариулт нь хангалтгүй гэж үзвэл гомдлыг дахин хянан үзэх боломжтой.

## **8. Аюулгүй байдал бусад баримтлах зүйлс**

ТомЁ зуны зуслан хөтөлбөрт ойр орчимд дуу чимээг үргэлж хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах ёстойг сурагчид мэдэж байх ёстой. ТомЁ зуны зуслан хөтөлбөрийн үед сурагчийн аюулгүй байдал хамгийн чухал тул аливаа орохыг хориглосон байр болон өрөө рүү орохыг хориглоно.

### **8.1 Авч ирэхийг хориглох хүнс:**

Будагтай хоол хүнс: Үүнд чацаргана, аньс, нэрс гэх мэт  
Бэлэн гоймон, Бохь  
Чанаргүй жимс, чихэр  
Лаазалсан бүтээгдэхүүн  
Хурдан муудах хүнс  
Хэт үнэртэй хүнсний зүйл

## **8.2 Гар утасны хэрэглээ**

Зуслангийн байрны дүрэм журмыг баримтлан багш ажилчдыг хүндэтгэн гар утсыг хичээл дундуур болон амрах цаг (22:00) эхэлснээс хойш ашиглахгүй ба гар утсыг оройд хураан авч өглөө буцаан олгох зохицуулалттай байна.

## **8.3 Яаралтай тусламж**

Осол, гал түймэр зэрэг ноцтой нөхцөл байдлын үед сурагчид 103 руу залгаж яаралтай тусламж авах. Хэрэв хэн ч шууд аюулд өртөөгүй бол зуны зуслангийн менежерийг яаралтай дуудна.

## **8.4 Ан амьтан**

Зэрлэг амьтан, молтогчин туулай, зурам, хулгана гэх мэт амьтанд ойртох, хооллохыг хориглоно.

## **8.5 Эрүүл мэнд**

Хэрэв та эсвэл хэн нэг сурагч өвдсөн бол Зуны зуслангийн менежерт аль болох хурдан мэдэгдэх хэрэгтэй. Жижиг бэртэл шалбархай зэрэгт удирдагч багшаараа дамжуулан яаралтай тусламжийн хайрцгаас боолт, ариутгалын бодис авч хэрэглэж болох ч сурагч ноцтой өвдвөл бид тэднийг аль болох хамгийн ойр байрлах эмнэлэгт үзүүлж, эмчийн үзлэгт хамруулах арга хэмжээг авна.

## **8.6 Төлбөр буцаалт**

Ямар ч тохиолдолд төлбөр буцаагдахгүй болохыг анхаарна уу.